

“ЦЭЦИЙ” САЛХИН ЦАХИЛГААН СТАНЦ

Улс: Монгол

Төслийн дугаар: 47949

Бизнесийн салбар: Цахилгаан, эрчим хүч

Төрөл: Хувийн

Байгаль орчны нөлөөллийн зэрэглэл: В

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр батлагдсан өдөр: 2016 оны 7 дугаар сарын 20

Төлөв: Санхүүжилт хийж байгаа

Төслийн товч танилцуулгыг нийтэлсэн өдөр: 2016 оны 6 дугаар сарын 10

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Өмнөговьд, Улаанбаатар хотоос 542 км-ийн зайд 50 МВт хүчин чадалтай “Цэций” салхин цахилгаан станц барих, ашиглалтанд оруулахад зориулж Клин Энержи Ази ХХК (“Компани”) -д 25 хүртэлх сая америк долларын тэргүүн ээлжинд эргэн төлөгдөх зээл (senior loan) олгох төсөл.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

“Цэций” салхин цахилгаан станц нь ЕСБХБ-наас 2012 онд санхүүжүүлэн байгуулсан 50 МВт-ын “Салхит” салхин станцын дараа Монгол улсад байгуулж буй салхины эрчим хүчний хоёр дахь төсөл болж байна. Энэ төслийн хэрэгжилт нь Монголын нүүрс хүчлийн хийн үйлдвэрлэлийг багасгах, мөн эрчим хүчний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангахад хувь нэмэр оруулах юм. Мөн уг төсөл Монгол улсын эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой.

ШИЛЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛ

Төсөл нь Монгол улсад чөлөөт зах зээлийг хөгжүүлэхэд дараах байдлаар нөлөө үзүүлэх болно. Үүнд:

- (i) Монгол улсын хувийн өмчит хоёр дахь эрчим хүч үйлдвэрлэгч, салхин цахилгаан станцын төслийн хувьд уг Төсөл нь нийтийн анхаарлын төвд байх болно. Төсөл амжилтай хэрэгжих нь тухайн салбарт шинэ хөрөнгө оруулагчдыг татахад чухал үр нөлөөтэй байх юм;
- (ii) Монгол улсын цахилгаан эрчим хүчний салбар нь төрийн өмчит компаниуд давамгайлсан байдаг. Төслийн үр дүнд Монголын эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн шинэ оролцогч бий болох юм;
- (iii) Төсөл нь нүүрсээр галалдаг эрчим хүчний эх үүсвэр давамгайлсан салбарт төрөлжүүлэх, Монгол улсын хүлэмжийн хий (CO₂) ялгаруулалтыг жилд 151'280 тонн хүртэлх хэмжээгээр бууруулахад туслах болно.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

КЛИН ЭНЕРЖИ АЗИ ХХК

Зээлдэгч нь Монгол Улсад бүртгэгдсэн тусгай зорилго бүхий хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Компаний 51%-г харилцаа холбоо, үл хөдлөх хөрөнгө, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын толгой компани болох Ньюком ХХК эзэмшдэг. Үлдсэн 49%-г Японы харилцаа холбоо, технологийн салбарын конгломерат болох Софтбанк Групп корпорацийн сэргээгдэх эрчим хүч хариуцсан

салбар компани СБ Энержи компани эзэмшиж байна. Ньюком ХХК нь Монгол дах хувийн өмчит анхны бөгөөд цорын ганц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгч салхин станц болох "Салхит" салхин станцын дийлэнх хувийг эзэмшдэг.

ЕСБХБ-НЫ САНХҮҮЖИЛТ

25'000'000.00 америк доллар

25 сая америк долларын (21,7 сая евротой тэнцэх) тэргүүн ээлжинд төлөгдөх эрхтэй баталгаат зээлийг (senior secured loan) тус Компанид хязгаарлагдмал баталгаатай төслийн санхүүжилтын үндсэн дээр олгоно.

ТӨСЛИЙН НИЙТ ӨРТӨГ

120'000'000.00 америк доллар

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИЛЦАА

Зэрэглэл "В" (2014). Банкны Байгаль орчин, нийгмийн харилцааны нарийвчилсан үнэлгээ (ESDD) болон байгаль орчин, нийгмийн харилцааны хараат бус зөвлөх (IESC)-өөр хийлгэсэн үнэлгээ нь тус тус Төсөл нь ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагыг хангаж байгааг баталгуужуулсан.

Шаардлагууд ба Европын Холбооны холбогдох удирдамжууд. Байгаль орчин, нийгмийн харилцааны нарийвчилсан үнэлгээ (ESDD)-ний ажил дотор байгаль орчин, нийгмийн харилцааны хараат бус зөвлөхийг (IESC) төслийн газар дээр ажиллуулах, Төслийн салхин станц болон түүний дамжуулах шугамын Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг (ESIA) хянан үзэх, Техникийн бус тойм (NTS), Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (SEP), Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнүүд (ESMPs) болон Газрын эзэмшил шилжүүлэн авах хүрээ (LAF) боловсруулах ажлууд багтсан.

Эдгээр баримт бичгийг Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (ESAP)-ний хамт Компаний вэбсайт дээр [англи](#), [монгол](#) хэлээр байршуулан, нийтэд ил болгосон болно.

50 МВт-ын салхин цахилгаан станцын төсөл нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт хэрэгжих юм. Хамгийн ойр орших суурин газар нь Цогтцэций сум бөгөөд төслийн талбайгаас хойд зүгт 22 км-ийн зайтай байдаг. Төслийн зориулалттай газар нь төрийн эзэмшилд байдаг бөгөөд уг газрыг төслийн компани түрээслэн авсан. Орон нутгийн байгаль орчны шаардлагуудыг хангасны зэрэгцээ барилгын ажил, үйл ажиллагаа явуулах, тоног төхөөрөмж шинэчлэхтэй холбоотой эрсдэл, нөлөөллийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ESIA) хийлгэсэн болно. ESIA үнэлгээнд анхаарсан гол асуудлуудын дотор агаар (тоос шороо, чимээ шуугиан, г.м.), ус, хаягдлын менежмент, тээврийн хөдөлгөөний менежмент, орчин тойрны үзэмжид (салхин турбин, сэнсний эргэлтийн сүүдэр) үзүүлэх нөлөөлөл, нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, гэрээт байгууллагуудын менежмент, биологийн төрөл зүйл, соёлын өв, нутгийн малчдад учирч болох эдийн засгийн хохирол (бэлчээрийн талбайгаа алдах, г.м.) зэрэг орж байна. ESIA үнэлгээний нэг хэсэг болгон, шувууны судалгаа, түүний дотор салхин тээрэмтэй мөргөлдөх магадлалын загварчлал гаргасан бөгөөд хамгаалах ёстой, эсвэл амьдрах орчин нь онцлог шувууны аливаа төрөлд тухайн төсөл сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдгийг үүгээр баталсан болно. Эцэст нь, төслийн нутаг дэвсгэрт (түүний дотор дамжуулах шугамын коридор) аж төрж байгаа

малчдад үзүүлж болох нөлөөллийг сайтар ойлгох зорилгоор холбогдох талуудын картографын судалгаа хийсэн бөгөөд үүний үр дүнд тухайн төсөл малчин айл өрхүүдийг албадан нүүлгэхэд хүргэхгүй, эдийн засгийн хувьд тааламжгүй нөхцөл байдалд оруулах магадлал бага байгааг тогтоосон.

Клин Энержи Ази ХХК нь 2015-2016 онуудад, ESIA үнэлгээний ажлын цар хүрээг тодорхойлох үед, нутгийн иргэдэд Төсөл, түүний хүлээгдэж буй үр дүнг танилцуулж тайлбарлах, тэдний санал хүсэлтийг сайн ойлгох зорилгоор олон нийттэй дөрвөн удаагийн уулзалт зохион байгуулсан. Тав дахь уулзалтыг ЕСБХБ-ны нээлтэй тайлагнах хугацаанд зохион байгуулна.

ESIA үнэлгээнд төлөвлөсөн Төслийн сөрөг нөлөөг саармагжуулах арга хэмжээнүүдийг үр дүнтэй удирдаж хэрэгжүүлэхийн тулд Байгаль орчин, нийгмийн харилцааны менежментийн төлөвлөгөөнүүд (ESMPs)-ийг боловсруулан. ESMP нь Төслийн барилгын ажлын үед Инженеринг, худалдан авалт, барилгын ажил (EPC) хариуцсан гэрээт байгууллагын хийх, ашиглалтын үед талбай хариуцсан оператор байгууллагын хийх болгох байгаль орчны менежментийн систем (EMS)-үүдийн суурь болох юм.

Клин Энержи Ази ХХК Төслийн байгаль орчин, нийгмийн үүрэг хариуцлагын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал хариуцсан мэргэшсэн ажилтан, мөн олон нийтийн харилцаа хариуцсан ажилтан зэрэг тусгай ажлын байр бий болгосон ажиллаж байна.

ESMP төлөвлөгөөнүүдийн зэрэгцээ, Банкны Гүйцэтгэлийн шаардлагууд (PRs)-ад нийцүүлэх зорилгоор Байгаль орчин, нийгмийн харилцааны үйл ажиллагааны төлөвлөгөө (ESAP)-г Компанитай тохиролцсон. Уг төлөвлөгөөнд (i) хүний нөөцийн бодлогыг Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)-ын суурь шаардлагуудад нийцүүлэн боловсруулах, (ii) дамжуулах шугам сүлжээний тулгуур дээр шувуу үргээх төхөөрөмжүүд байрлуулах, (iii) төслийн нөлөөлөлд орсон иргэд, малчидтай үргэлжлүүлэн зөвлөлдөж ажиллах зэрэг төрөл бүрийн арга хэмжээнүүдийг тусгасан.

Эцэст нь тэмдэглэхэд, Банкны мэргэжилтнүүд, томилогдсон зөвлөхүүд Компани болон түүний үйл ажиллагааг байнга хянаж ажиллах болно.

[Техникийн бус асуудлуудын товч](#)

ТЕХНИК ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төсөл “Япон-ЕСБХБ-ны Хамтын ажиллагааны сан”-гийн шугамаар Японы засгийн газраас олгох 746,125 хүртлэх америк долларын буцалтгүй тусламжийг авах хүлээлттэй байгаа. Уг буцалтгүй тусламжаар Тавантолгой дэд станцыг өргөтгөхөд зориулж төрийн өмчит Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ХК-д дэмжлэг үзүүлэх юм. Энэхүү дэд станц нь “Цэций” салхин станцыг төвийн бүсийн дамжуулах сүлжээнд холбох болно.

КОМПАНИЙ ХОЛБОО БАРИХ ХАЯГ

[Саруул Дамдинбал](#)

Утас: 976-11-313183

Вэбсайт: <http://newcom.mn/en/company/55>

Найман Зовхис барилга, 10 дугаар давхар

21 Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14251

БИЗНЕСИЙН БОЛОМЖУУД

Бизнесийн боломж, худалдан авалтын асуудлаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

Төрийн хэвшлийн төслийн асуудлаар ЕСБХБ-ны [Худалдан авалтын газарт](#) хандах хаяг:

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

ЕРӨНХИЙ АСУУЛТУУД

ЕСБХБ-ны төслийн холбогдолтой боловч худалдан авалттай холбоогүй асуудлаар хандах хаяг:

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО (PIP)

Олон нийтийн мэдээллийн бодлого (PIP) нь ЕСБХБ-наас өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааны талаархи мэдээлэл, ойлголтыг илүү сайн түгээх зорилгоор мэдээллийг хэрхэн ил тод болгох, холбогдох талуудтай хэрхэн зөвлөлдөж ажиллах зарчмыг тодорхойлж өгдөг.

[Олон нийтийн мэдээллийн бодлогын бүрэн эх хувь](#)

ТӨСЛИЙН САНАЛ ГОМДЛЫН МЕХАНИЗМ (PCM)

ЕСБХБ нь Банкны санхүүжилттэй төслийн зүгээс ямар нэг хохирол учруулсан, учруулах магадлалтай гэх асуудлаар нэг буюу хэсэг хувь хүн, эсвэл аль нэг байгууллагаас гаргаж болох гомдлыг хараат бусаар хянан шийдвэрлэх боломж олгох үүднээс Төслийн санал гомдлын механизм (PCM) бий болгосон.

[Төслийн санал гомдлын механизм](#)

PCM механизмын хүрээнд гаргах аливаа санал гомдлыг PCM-ын [Процедурын журамд](#) заасан цаг хугацааны дотор гаргах ёстой. Та тухайн асуудлаар санал гомдол гаргах эрхтэй эсэхээ сайн мэдэхгүй байгаа бол PCM хариуцсан ажилтантай (pcm@ebrd.com) холбогдож тусламж авна уу.

<http://www.ebrd.com/work-with-us/projects/psd/tsetsii-windfarm.html>